

2025 оны 08 сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

БАТЛАВ
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Л.МӨНХБААТАР

**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН
2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Баялгийн сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.58 дахь заалтад ““Үндэсний баялгийн сангийн төсөв” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу төрөлжсөн сан бүрд төвлөрүүлж, зарцуулах, хуримтлал үүсгэх зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж тус тус заасан нь Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний баялгийн сангийн талаар тодорхой зорилтууд тусгагдсан. Тухайлбал, газрын хэвлий дэх байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх, Ирээдүйн өв санд ирээдүй үедээ хуримтлал үүсгэх, мөн иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүд хэрэгжиж эхлээд байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын хүрээнд Засгийн газрын 2025 оны 72 дугаар тогтоолоор Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлагдсан. Улмаар Монголбанктай гэрээ байгуулан сангийн хөрөнгийг Франц, Английн төв банканд хадгаламж хэлбэрээр байршуулж байна.

Түүнчлэн, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 179, 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 228 дугаар тогтоолууд тус тус батлагдаж, тус сангийн мөнгөн хөрөнгийг өсгөж арвижуулах зорилгоор “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г Монголбанктай байгуулаад байна.

Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хууль батлагдсанаар Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангийн хөрөнгийг хуульд заасан орлогын эх үүсвэрээр өсгөж арвижуулах нөхцөл бүрдэнэ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомжийн талаар;

Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн санд 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, төрөлжсөн сангуудад хуримтлуулах хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Ирээдүйн өв сан болон Хуримтлалын санд 2026 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж хуримтлуулах бөгөөд Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Ирээдүйн өв санд хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар үнэ цэнийг өсгөх, арвижуулах боломж бүрдэнэ.

Түүнчлэн, Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу бодлогын хүүгээс багагүй өгөөжөөр өсгөж арвижуулах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт,

**өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн
төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---